

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СНАГ-2024/17/НА-СТА-ТЕЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 51-261885 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn Ахлах аудитор: О.Баярмаа Утас: 51-261628 Цахим хаяг: bayarmaa@audit.gov.mn Аудитор: Ж.Бүжинханд Утас: 51-261628 Цахим хаяг: bujinlkhandj@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ГАНЗОРИГ  
ТАНАА

2024.04.25 № 1138  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан, зөвлөгөөн, мэдээллийг цахимаар дамжуулах зорилгоор 32.5 сая төгрөгийн E-JUDGES вэб сайтыг ашиглаж эхэлсэн.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн тайлант онд шинээр томилогдсон болон анхан шатны, эрүү, иргэн, захиргааны хэргийн ерөнхий шүүгч нарын мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, нийт 360.0 сая төгрөгийг зарцуулсан.

## Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын дээд шүүхийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 58 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.9 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	613,323.8	710,387.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	161,000.0	120,120.0
33	АВЛАГА	-	12,825.0
34	УРЬДЧИЛГАА	36,872.9	69,466.1
35	БАРАА МАТЕРИАЛ	415,450.9	507,976.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,690,560.2	6,207,285.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,690,560.2	6,207,285.7
39200	Биет хөрөнгө	6,265,835.2	5,783,236.0
39300	Биет бус хөрөнгө	424,725.0	424,049.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,303,884.0	6,917,673.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,174.6	12,825.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,174.6	12,825.0
41300	Өглөг	1,174.6	12,825.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,302,709.5	6,904,848.3
51	Засгийн газрын хувь оролцоо	7,302,709.5	6,904,848.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,428,220.1	1,428,220.1
51200	Хуримтлагдсан үр дүн	4,222,661.2	3,824,800.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,651,828.2	1,651,828.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,303,884.0	6,917,673.3

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	9,738,574.4	10,967,700.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,510.1	1,562.6
120	Нийтлэг татварын бус орлого	58,510.1	1,562.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,680,064.3	10,966,137.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,036,590.2	11,365,561.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,036,590.2	11,365,561.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,585,047.4	10,314,539.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,378,187.8	6,773,493.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	563,935.9	847,715.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,653.4	189,259.1
2104	Хангамж, бараа материалын зардал	356,563.4	410,258.8
2105	Нормативт зардал	1,664.5	50.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	109,680.1	162,188.5
2107	Томилолт, зочны зардал	112,033.5	204,721.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	149,319.8	369,443.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	827,008.9	1,357,409.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,451,542.8	1,051,021.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	701,984.2	(397,861.2)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,845.0	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	695,139.2	(397,861.2)

## 2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	9,841,099.3	10,980,245.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	161,035.0	14,107.6
120	Нийтлэг татварын бус орлого	161,035.0	14,107.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,680,064.3	10,966,137.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,627,226.0	10,656,466.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,627,226.0	10,656,466.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,175,683.2	9,592,619.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,537,542.2	6,773,493.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	563,541.3	847,715.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,473.4	189,259.1
2104	Хангамж, бараа материалын зардал	262,838.6	445,681.2
2105	Нормативт зардал	2,999.0	4,824.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	167,930.4	160,817.1
2107	Томилолт, зочны зардал	123,800.4	204,721.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,482.8	451,441.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	232,075.0	514,666.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,451,542.8	1,063,846.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,213,873.4	323,779.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,052,873.4	364,659.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,052,873.4	364,659.4
2200	Дотоод эх үүсвэрээр	1,052,873.4	364,659.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,052,873.4)	(364,659.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	161,000.0	(40,880.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	161,000.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	161,000.0	120,120.0

## 2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,602,170.2	6,602,170.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,400.0	5,400.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,607,570.2	6,607,570.2
9	Тайлант үеийн үр дүн	695,139.2	695,139.2
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,302,709.5	7,302,709.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,302,709.5	7,302,709.5
19	Тайлант үеийн үр дүн	(397,861.2)	(397,861.2)
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,904,848.3	6,904,848.3

## 2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,548,847,000.00	10,039,619,110.06	1,509,227,889.94	86.9
УРСГАЛ ЗАРДАЛ	11,548,847,000.00	10,039,619,110.06	1,509,227,889.94	86.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,776,640,000.00	9,891,394,110.06	885,245,889.94	91.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,407,837,800.00	6,773,493,672.70	634,344,127.30	91.4
Үндсэн цалин	3,956,492,600.00	3,984,465,849.70	(27,973,249.70)	100.7
Нэмэгдэл	2,217,552,500.00	1,389,306,169.68	828,246,330.32	62.7
Унаа хоолны хөнгөлөлт	882,392,000.00	593,457,061.54	288,934,938.46	67.3
Урамшуулал	351,400,700.00	806,264,591.78	(454,863,891.78)	229.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	925,979,500.00	847,714,995.92	78,264,504.08	91.5
Тэтгэврийн даатгал	629,666,000.00	563,072,787.98	66,593,212.02	89.4
Тэтгэмжийн даатгал	74,078,200.00	82,482,505.76	(8,404,305.76)	111.3
ҮОМШӨ-ний даатгал	59,262,800.00	54,231,817.46	5,030,982.54	91.5
Ажилгүйдлийн даатгал	14,815,600.00	13,401,733.59	1,413,866.41	90.5
Эрүүл мэндийн даатгал	148,156,900.00	134,526,151.13	13,630,748.87	90.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,800,900.00	143,436,980.70	21,363,919.30	87.0
Гэрэл, цахилгаан	52,217,700.00	45,011,981.92	7,205,718.08	86.2
Түлш, халаалт	54,000,000.00	42,263,225.96	11,736,774.04	78.3
Цэвэр, бохир ус	9,883,200.00	8,101,973.00	1,781,227.00	82.0
Байрны түрээс	48,700,000.00	48,059,799.82	640,200.18	98.7
Хангамж, бараа материалын зардал	462,853,400.00	445,681,238.04	17,172,161.96	96.3
Бичиг хэрэг	137,143,400.00	133,097,195.50	4,046,204.50	97.0
Тээвэр, шатахуун	54,000,000.00	55,464,000.00	(1,464,000.00)	102.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,200,000.00	53,964,335.54	15,235,664.46	78.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,000,000.00	10,442,400.00	(2,442,400.00)	130.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	194,510,000.00	192,713,307.00	1,796,693.00	99.1
Нормативт зардал	10,500,000.00	4,824,000.00	5,676,000.00	45.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,500,000.00	4,824,000.00	5,676,000.00	45.9
Эд хогшил, урсгал засварын зардал	492,400,300.00	476,906,526.00	15,493,774.00	96.9
Багаж, техник, хэрэгсэл	238,000,000.00	237,115,915.00	884,085.00	99.6
Тавилга	119,306,000.00	105,845,900.00	13,460,100.00	88.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,548,000.00	15,228,000.00	320,000.00	97.9
Урсгал засвар	119,546,300.00	118,716,711.00	829,589.00	99.3
Томилолт, зочны зардал	216,400,000.00	204,721,205.50	11,678,794.50	94.6
Гадаад албан томилолт	201,500,000.00	199,267,205.50	2,232,794.50	98.9
Дотоод албан томилолт	14,900,000.00	5,454,000.00	9,446,000.00	36.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	527,868,100.00	479,948,982.70	47,919,117.30	90.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	281,008,500.00	254,216,518.79	26,791,981.21	90.5
Даатгалын үйлчилгээ	66,555,000.00	61,182,740.00	5,372,260.00	91.9
Тээврийн хэрэгслийн татвар	5,660,500.00	3,614,650.00	2,045,850.00	63.9

Монгол улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	151,644,100.00	147,328,728.91	4,315,371.09	97.2
Газрын төлбөр	23,000,000.00	13,606,345.00	9,393,655.00	59.2
Бараа үйлчилгээний бусад зардал	568,000,000.00	514,666,508.50	53,333,491.50	90.6
Бараа үйлчилгээний бусад зардал	18,000,000.00	5,383,669.00	12,616,331.00	29.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000,000.00	509,282,839.50	40,717,160.50	92.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	772,207,000.00	148,225,000.00	623,982,000.00	19.2
Бусад урсгал шилжүүлэг	772,207,000.00	148,225,000.00	623,982,000.00	19.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	733,091,100.00	115,200,000.00	617,891,100.00	15.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,115,900.00	33,025,000.00	6,090,900.00	84.4
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>11,548,847,000.00</b>	<b>10,039,619,110.06</b>	<b>1,509,227,889.94</b>	<b>86.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>11,548,847,000.00</b>	<b>10,039,619,110.06</b>	<b>1,509,227,889.94</b>	<b>86.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	11,548,847,000.00	10,039,619,110.06	1,509,227,889.94	86.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	2	2	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>219</b>	<b>166</b>	<b>53</b>	<b>75.8</b>
Удирдах ажилтан	13	11	2	84.6
Гүйцэтгэх ажилтан	173	123	50	71.1
Үйлчлэх ажилтан	33	32	1	96.9

## 2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	-	51,382,319.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	51,382,319.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	51,382,319.00
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	51,382,319.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	51,382,319.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	45,822,077.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	45,822,077.00
Гэрэл, цахилгаан	-	30,718,225.00
Түлш, халаалт	-	11,821,925.00
Цэвэр, бохир ус	-	3,281,927.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,560,242.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,560,242.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,560,242.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64.3 сая төгрөгийн 3 алдааг илрүүлж, аудитын явцад залруулсан байна. Тухайлбал:

- Санхүүгийн байдлын тайланд 12.8 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага, барьцаа хөрөнгийн өглөгийг тайлагнаагүй;
- Бусад хангамжийн материалд үнэ төлбөргүй хүлээн авсан 0.1 сая төгрөгийн номыг орлогод аваагүй;
- Үр дүнгийн тайланд 51.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бусад орлогоор тайлагнасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, түүвэрт хамруулсан байна.

Аудитаар нийт 453.5 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс 3.9 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 449.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 зөвлөмж өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Монгол Улсын дээд шүүх тайлант онд нэр бүхий 5 албан хаагчид нийт 2.0 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий албан хаагч нарт илүү олгосон 2.0 сая төгрөгийн цалинг зөрчил гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн тайлант онд нэр бүхий 2 албан хаагчид нийт 1.9 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий албан хаагч нарт илүү олгосон 3.9 сая төгрөгийн шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### Монгол Улсын дээд шүүхэд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Улсын дээд шүүхийн 16 авто тээврийн хэрэгсэл нь бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авто тээврийн хэрэгсэлд тод өнгийн дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болгох зөвлөмж өгсөн.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт 2.** Монгол Улсын дээд шүүх нь Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 44.4 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 50.4 сая төгрөгийн 5 шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг байршуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

### 3. Нягтлан бодох бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

**Илрүүлэлт 3.** Татварын цахим системийн 850.9 сая төгрөгийн өр төлбөр, авлагын үлдэгдэл нь санхүүгийн тайланд тайлагнасан дүнгээс зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Татварын цахим системийн өр төлбөр, авлагын зөрүүг арилгаж, татварын тайланг үнэн зөв тайлагнаж байх.

### 4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

**Илрүүлэлт 4.** Улсын дээд шүүхийн 16.7 сая төгрөгийн 16 төрлийн 23 ширхэг үндсэн хөрөнгийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнд гэрээгүйгээр ашиглуулж байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1-т "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнд гэрээгүйгээр хөрөнгө ашиглуулж байгаа зөрчлийг арилгах.

### Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнд:

#### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт 5.** Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн нь Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 206.8 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 12.4 сая төгрөгийн 6 шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв,

өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг байршуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

2. Нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт 6.** Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 283 албан хаагчид албан томилолтын хуудасгүй 95.1 сая төгрөгийн албан томилолтыг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын бүрдэл хангасан баримтаар зарлагын гүйлгээг хийж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт 7.** Тайлант онд хийлгэсэн 20.3 сая төгрөгийн вэб сайтыг биет бус хөрөнгөд бүртгээгүй, зардлаар тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Вэб сайтыг үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгөд залруулан бүртгэх.

**Илрүүлэлт 8.** Урьдчилж төлсөн авто машины зогсоолын түрээсийн 3.2 сая төгрөгийг шууд зардалд бичиж, урьдчилж гарсан зардлаар тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Гэрээний дагуу урьдчилж төлсөн зардлыг санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 64.3 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 64.3 сая төгрөгийн 3 алдааг залруулсан байна.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Монгол Улсын дээд шүүх /аппарат/	3	64.3	2	12.9	1	51.4	3	64.3	-	-	-	-
Дүн	3	64.3	2	12.9	1	51.4	3	64.3	-	-	-	-

Аудитаар нийт 139.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 3.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 135.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Монгол Улсын дээд шүүх /аппарат/	3	18.7	1	2.0	-	-	2	16.7	-	-
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн	4	120.6	1	1.9	-	-	3	118.7	-	-
Дүн	7	139.3	2	3.9	-	-	5	135.4	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 314.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 314.2 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Монгол Улсын дээд шүүх /аппарат/	1	94.9	-	-	-	-	1	94.9
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн	1	219.3	-	-	-	-	1	219.3
Дүн	2	314.2	-	-	-	-	2	314.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Монгол Улсын дээд шүүх /аппарат/	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	3	314.2	-	-	-	-	3	314.2